



ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠨᠢᠶᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠰᠢᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ- 2018 онд /урьдчилсан дүнгээр/



2019.01.17

ХҮН АМ




2018 оны урьдчилсан дүнгээр 69.4 мянган байнгын оршин суугчтай болж 2017 оны жилийн эцсийн суурин хүн амын мэдээнээс 1.8 хувиар буюу 1194 хүнээр өссөн байна.



Эрүүл мэндийн газрын мэдээгээр 2018 оны 12 сард 1371 хүүхэд шинээр мэндэлж, 402 хүн нас барсан бөгөөд хүн амын цэвэр өсөлт 969 байна. Төрсөн хүүхэд өмнөх оноос 15(1.1%)-аар, хүн амын цэвэр өсөлт 57(5.6%)-аар тус тус буурч, нас барсан хүн 42(11.7%)-оор өсчээ.

1000 хүнд ногдох төрөлт 19.9, нас баралт 5.8 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.6 пунктээр буурч, нас баралт 0.5 пунктээр өссөн байна.

Хүн амын насны бүтэц, хувиар, 2018 онд



2017 оноос

0-14 нас +0,6 пункт,

15-59 нас -0,9 пункт,

60 < нас +0,3 пункт,



ЭРҮҮЛ МЭНД



Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 12 сард 1365 эх амаржиж, 1371 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 47(3.6%)-оор, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 15(1.1%)-аар тус тус буурч, 402 хүн нас барсан нь 42(11.7%)-оор тус тус өссөн байна.



Нялхсын эндэгдэл 16 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1-ээр өсчээ.



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй



Халдварт өвчний 737 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 50(7.3%)-аар өсчээ.




Халдварт өвчний тохиолдол өсөхөд заг хүйтэн 53.6 хувиар, цусан суулга 41.0 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Урьдчилсан мэдээлэл




ЭРҮҮЛ МЭНД


Урьдчилан сэргийлэх тарилга



Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн ХҮНИЙ ТОО




Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд ногдох




Урьдчилан сэргийлэх тарилга	-0,2%	▼
Нялхсын эндэгдэл	-5,9 %	▼
Эмчлүүлсэн хүн	+5,4%	▲
Амбулторын үзлэг	+4,2 пункт	▲

Нас баралт өвчний шалтгаанаар 2018 оны 12-р сард






Өрхийн зарим үзүүлэлт



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо бүгд, үүнээс 0-14 насны хүүхэд






ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо



Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 32 (3.2) хүнээр буурч, өмнөх сараас 248 (20.0%) хүнээр буурч 993 болсны 497 (50.1%) нь эмэгтэйчүүд байна.



Ажилгүйдлийн түвшин, аймаг, нийслэлээр



2018 оны 3-р улирал

АХС-ны үр дүнгээр тооцсон ажилгүйдлийн түвшин 2.6 (өмнөх оны 4-р улирлаас 4.7 пунктээр буурсан)





Ажилгүй иргэдийн тоо, сумаар



Шинээр бий болгосон ажлын байр, э.з-ийн салбарын ангилалаар



Байнгын ажлын байр 746 (73.1 %)



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

01

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 онд 33714.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4539.1 (15.6%) сая төгрөгөөр өссөн байна.

02

Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 онд өмнөх оны мөн үеэс 4539.1 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 3790.7(21.7%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 430.3 (21.8%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгал 632.0 (21.8%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 177.2(22.1%) өссөн нь нөлөөлсөн байна.

03

Нийгмийн даатгалын сангийн зарлага 43933.8 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2964.1 (7.2%) сая.төгрөгөөр өссөн байна.

04

Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 32887.0 (74.9%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2449.2 (5.6%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 5220.3 (11.9%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2514.0 (5.7%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 863.3 (2.0%) сая төгрөгийг зарцуулжээ.

05

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2018 онд нийгмийн халамжийн сангаас 30670 иргэнд 8064.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 12196 (66.0%)-оор буурч, олгосон тэтгэвэр тэтгэмж 2094.8.1 (35.1%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

БОЛОВСРОЛ

Ерөнхий боловсролын сургуульд:



www.shutterstock.com • 322062854


2018/2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 22 сургуульд 13009 сурагч суралцаж байгаа нь өмнөх оны мөн үеэс 250(2.0%) өссөн байна.

Их, дээд сургуульд:



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 577, АШУҮИС-д 566 нийт 1143 оюутан суралцаж байгаа өмнөх оноос 81(6.6)-ээр буурчээ.



Бүх шатны сургуульд суралцагсад





ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, үйлдэгдсэн цагаар



Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2018 онд 517 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 150 хүн гэмтэж, 27 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 137 (20.9%)-оор, гэмтсэн хүний тоо 63 (29.6%)-аар буурч, нас барсан хүний тоо 1 (3.8%)-ээр нэмэгдсэн байна.



Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэрэг буурахад хүний өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 62 (22.1%)-оор, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 28 (16.4%)-аар, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 22 (45.8%)-оор, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 17 (28.8%)-оор, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 15 (60.0%)-аар, хүний амины гэмт хэрэг 10 (55.6%)-аар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 5 (50.0%)-аар, авилгын гэмт хэрэг 2 (33.3%)-оор буурсан.



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 2301.0 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2121.3 (47.9 %) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 728.3 (31.6%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар




Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Алтанширээ, Даланжаргалан, Мандах, Улаанбадрах, Хөвсгөл сумдад нэмэгдэж, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.



БАНК, ЗЭЭЛ

Хадгаламжийн үлдэгдэл, сая.төг



Зээлийн өрийн үлдэгдэл, сая.төг



-Иргэдийн мөнгөн хадгаламж 29.3 тэрбум төгрөг нэмэгдсэн

- Нэг хадгаламж эзэмшигчдэд 1503.2 мянган төгрөг ногдож байна

- Нэг хүнд дундажаар 1587.0 мянган төгрөг ногдож байна.

- Хадгаламж эзэмшичийн тоо 7.5 % нэмэгдсэн

-Хадгаламжийн үлдэгдэл 37.3 % өссөн

- Зээлдэгчийн тоо 12.1 хувиар нэмэгдсэн

- Зээлийн өрийн үлдэгдэл 41.5 хувиар өссөн




ТӨСӨВ, САНХҮҮ

2018 оны урьдчилсан дүнгээр орон нутгийн төсөвт 28466.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 61587.2 сая төгрөг зарцуулжээ.



Орон нутгийн төсвийн орлого, сая төг

Орон нутгийн төсвийн зарлага, сая төг





ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.3 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 1.7 хувь, хувцас бөс бараа, гутал 0.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 10.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 3.2 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 4.7 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 2.7 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 12.7 хувь, тээвэрийн бүлэг 8.8 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 1.6 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 4.4 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 5.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Улаанбаатар, 2014 оны 10 сарын 15




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс, 2014 - 2018 оны сар бүрээр (өмнөх оны 12-р сар=100)






Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн сарын өөрчлөлт, сүүлийн 5 жилээр, хувиар (өмнөх оны 12-р сар=100)



Инфляци нь үнийн ерөнхий түвшний өөрчлөлтийг харуулах бөгөөд хэрэглээний, бараа үйлчилгээний индекс(ХҮИ)-ээр "хувь"-иар илэрхийлэгдэнэ



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс, 2017-2018 оны сар бүрээр (өмнөх сар= 100)



Улсын Статистик Урьдчилсан Газар



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст 2147.2 мянган толгой мал тоологдсон. Нийт мал сүрэг 2017 оноос 7.3 хувь буюу 145.6 мянган толгойгоор өсчээ.



АДУУ:

139.9 мянган толгой, өмнөх оноос 5.0 хувиар өслөө.



ТЭМЭЭ:

42.8 мянган толгой, өмнөх оноос 5.1 хувиар өслөө.



ҮХЭР:

80.5 мянган толгой, өмнөх оноос 10.9 хувиар өслөө.



ХОНЬ:

925.8 мянган толгой, өмнөх оноос 7.5 хувиар өслөө.



ЯМАА:


958.2 мянган толгой, өмнөх оноос 7.2 хувиар өслөө.

2018 онд оны эхний нийт хээлтэгч малын 671.9 (79.4%) мянган эх мал төллөж, гарсан төлийн 659.4 (96.3%) мянган төл бойжуулжээ. Үүнийг өмнөх онтой харьцуулахад бойжсон төл 0.6 хувиар өссөн байна.

2018 онд 18.9 мянган толгой мал зүй бусаар хорогдсон нь оны эхний малын 0.9 хувьтай тэнцэж байна.



Нэг саяас дээш толгой мал тоолуулсан он, малын тоо, мянган.толгой




Малын тоо , толгойн хүрсэн дээд хэмжээ, оноор мян.толгой






Малын тоо, сумаар, мянган толгойгоор



Ундэсний Статистик



ХАМГИЙН ОЛОН МАЛТАЙ СУМДУУД, малын төрлөөр, толгойгоор



АДУУ

Дэлгэрэх	16539
Эрдэнэ	13234
Хатанбулаг	13150
Сайхандулаан	11202
Улаанбадрах	11075



ХОНЬ

Дэлгэрэх	107087
Даланжаргалан	92354
Айраг	85624
Иххэт	83265
Сайхандулаан	76676


НИЙТ МАЛ

Хатанбулаг	228584
Дэлгэрэх	206242
Сайхандулаан	182195
Даланжаргалан	176419
Мандах	171393



ТЭМЭЭ

Хатанбулаг	7750
Мандах	7716
Улаанбадрах	5211
Хөвсгөл	5117
Сайхандулаан	4686



ҮХЭР

Хатанбулаг	9972
Дэлгэрэх	8515
Иххэт	7290
Өргөн	7086
Эрдэнэ	6937



ЯМАА

Хатанбулаг	124450
Мандах	94213
Сайхандулаан	83205
Хөвсгөл	78827
Дэлгэрэх	72841



АЖ ҮЙЛДВЭР



2018 оны 12-р сард аж үйлдвэрийн салбарт оны үнээр 213.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 51.6 (31.8%) тэрбум төгрөгөөр өслөө.



Үүнд уул уурхай, олборлолтын салбар өмнөх оноос 32.2 тэрбум төгрөгөөр, мөн боловсруулах салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 19.7 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.




Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2018 оны 12-р сард 320.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 47.4(17.3%) тэрбум төгрөгөөр өслөө.


Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт салбарт эзлэх хувиар



2017 он



2018 он



2018 онд өмнөх оноос \пунктээр\

УУГ 1.2 ↓

Компани 3.0 ↑

Өрхийн аж ахуй 0.1 ↓





БАРИЛГА

2018 онд нийт 423234.8 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 2.3 дахин нэмэгдсэн байна.





МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
НЭГДСЭН САН

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН



Статистик 
 Мэдээ, мэдээлэл 
 Номын сан 
 Мэдлэгээ шалгах тоглоом 
 Валютын ханш 







аппликейшнаас
СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Social network

 www.facebook.com/StatisticMongolia/

 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас

 **1900-1212**